

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 13 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны есдүгээр сарын 07-ны 10 цаг 05 минутад эхэлж, 11 цаг 15 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Биеийн тамир, спортын газрын дарга, Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын бүртгэлийг 2017 оны 10 сарын 04-нд 09.00–12.00, 13.00-17.00 цагт, шалгалтыг 10 сарын 05-06-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авахыг ажлын албанд үүрэг болгов.	
2	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Тус аймгийн нутгийн захиргааны зарим байгууллагаас ирсэн төрийн захиргааны албан тушаалын дэс түшмэлийн 5, туслах түшмэлийн 4 нийт 9 сул орон тооны захиалгыг төрийн албаны нөөцийн зард зарлуулахаар шийдвэрлэж, ТАЗ-д хүргүүлэхээр болов.
3	Нийгмийн даатгалын хэлтсийн Гурвансайхан сум хариуцсан байцаагчийн ажлын байранд нэр дэвшүүлсэн Б.Ууганцэрэнг буцаасан тухай	Нийгмийн даатгалын хэлтсийн Гурвансайхан сум хариуцсан байцаагчийн ажлын байранд нэр дэвшүүлсэн Б.Ууганцэрэн тухайн албан тушаалд ажиллах өргөдлөө өгсөн байгаа тул Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст томилуулахаар буцаахаар шийдвэрлэв.
4	Мэргэжлийн хяналтын газрын Тээвэр /авто, өргөх машин механизм/-ийн хяналтын асуудал хариуцсан улсын байцаагчийн албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Мэргэжлийн хяналтын газрын Тээвэр /авто, өргөх машин механизм/-ийн хяналтын асуудал хариуцсан улсын байцаагчийн албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 106 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Нармандах овогтой Батболдыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА